

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн
Төлөөлөн удирдах зөвлөлийн
2023 оны 13 сарын 28 өдрийн 13 дугаар
тогтоолын хавсралт

ЭКСПОРТОД ГАРГАХ НҮҮРСНИЙ НЭЭЛТТЭЙ ЦАХИМ АРИЛЖААГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗААВАР

*/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 13 дугаар тогтоолоор нэмэлт,
өөрчлөлт оруулсан/*

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Экспортод гаргах нүүрсний нээлттэй цахим арилжаа (цаашид "цахим арилжаа" гэх)-г Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 466 дугаар тогтоолоор баталсан "Экспортод гаргах нүүрсний нээлттэй цахим арилжааны журам" (цаашид "Нүүрсний цахим арилжааны журам" гэх) -ын дагуу зохион байгуулахад энэхүү зааврыг баримтална.

Хоёр. Цахимаар арилжих нүүрсний захиалга болон худалдан авах санал гаргагчийн бүртгэл

А. Цахимаар арилжих нүүрсний захиалга

2.1. Нүүрсний цахим арилжаанд худалдагчаар оролцох хүсэлтэй хуулийн этгээд нь арилжаа зохион байгуулагчтай гэрээ байгуулж, захиалга бүртгэх үйлчилгээний хөлс төлснөөр арилжаанд оролцоно.

2.2. Худалдагч нь цахимаар арилжих нүүрсний захиалгыг дараах бүрдүүлбэрийн хамт арилжаа зохион байгуулагдахаас ажлын 7-оос доошгүй өдрийн өмнө арилжаа зохион байгуулагчид ирүүлнэ. Үүнд:

- 2.2.1. энэхүү зааврын Хавсралт 1-д тусгагдсан "Нүүрс арилжих захиалгын маяг";
- 2.2.2. энэхүү зааврын Хавсралт 2-т тусгагдсан "Экспортод гаргах нүүрсний цахим арилжааны зарын маяг" (Монгол, Хятад, Англи хэлээр);
- 2.2.3. итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүгнэлт.

2.3. Худалдагч нь захиалгад дурдсан мэдээлэл болон түүний бүрдүүлбэрийг үнэн зөв, бүрэн гүйцэд бөглөж цахим болон цаасан хэлбэрээр ирүүлнэ.

2.4. Арилжаа зохион байгуулагч нь захиалгыг хүлээн авч, ажлын 2 өдрийн дотор бүрдүүлбэрийг шалгана.

2.5. Хэрэв худалдагчийн захиалга нь шаардлага хангасан тохиолдолд арилжаа зохион байгуулагч зохих шийдвэрийн дагуу бүртгэлийг хийнэ.

(Энэ заалтад Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 13 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан)

2.6. Арилжаа зохион байгуулагч нь энэхүү зааврын 2.4-т заасан хугацаанд захиалгатай холбоотой шаардлагатай нэмэлт мэдээллийг худалдагчаас тодруулж, гаргуулан авч болно.

2.7. Дараах тохиолдолд арилжаа зохион байгуулагч захиалгыг бүртгэхээс татгалзаж болно. Үүнд:

2.7.1. захиалгын мэдээлэл болон бүрдүүлбэр дутуу;

2.7.2. захиалга, түүний бүрдүүлбэрт байгаа мэдээлэл алдаатай;

2.7.3. Нүүрсний цахим арилжааны журам болон энэхүү зааварт заасан бусад.

2.8. Худалдагчийн захиалгад тусгагдсан арилжаа зохион байгуулах хуваарийг арилжааны төлөвлөгөөтэй уялдуулах зорилгоор өөрчлөн бүртгэж болно.

Б. Худалдан авах санал гаргагчаар бүртгүүлэх

2.9. Шаардлага хангасан нүүрс худалдан авах санал гаргагч нь арилжаа зохион байгуулагдахаас ажлын 1-ээс доошгүй өдрийн өмнө системд бүртгүүлж, энэхүү зааврын Хавсралт 3-аар баталсан загварын дагуу "Экспортод гаргах нүүрсний цахим арилжаанд оролцох бүртгэлийн гэрээ"-г арилжаа зохион байгуулагчтай байгуулан, тухайн арилжааны дэнчинг Нүүрсний цахим арилжааны журмын 3.5-д заасны дагуу байршуулснаар арилжаанд оролцоно.

2.10. Худалдан авах санал гаргагч нь арилжаанд оролцохоор бүртгүүлэхдээ дараах баримт бичгийг арилжаа зохион байгуулагчид цахимаар ирүүлэх ба гадаад хэл дээрх баримт бичгийг Англи хэл дээрх албан ёсны орчуулгын хамт ирүүлнэ. Үүнд:

2.10.1. хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

2.10.2. татвар төлөгчийн гэрчилгээ, татвар төлөгчийн дугаар;

2.10.3. харилцагч банкны дансны тодорхойлолт;

2.10.4. Монгол Улсад бүртгэлтэй төлөөлөгчийн газартай бол холбогдох мэдээлэл;

2.10.5. арилжаа зохион байгуулагчаас шаардлагатай гэж үзсэн бусад.

2.11. Хэрэв татвар төлөгчийн гэрчилгээний дугаар нь хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээн дээр байгаа тохиолдолд энэхүү зааврын 2.10.2.-т заасан баримт бичгийг ирүүлэхгүй байж болно.

2.12. Энэхүү зааврын 2.10-т заасан баримт бичгийн бүрдэл хангасан этгээдийг худалдан авах санал гаргагчийн бүртгэлд бүртгэж, "Экспортод гаргах нүүрсний цахим арилжаанд оролцох бүртгэлийн гэрээ"-г байгуулна.

2.13. Худалдан авах санал гаргагч нь арилжаа эхлэхээс 30-аас доошгүй минутын өмнө арилжааны дэнчинг худалдагчийн сонгосон банкин дахь арилжаа зохион байгуулагчийн дансанд байршуулах ба шаардлагатай тохиолдолд гүйлгээний баримтыг comex@mse.mn цахим хаягт илгээнэ.

(Энэ заалтад Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 13 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан)

2.14. Дэнчингийн хэмжээ нь цахим арилжааны зард тусгагдсан нүүрсний доод үнээр илэрхийлсэн захиалгын нийт үнийн дүнгийн 5-аас доошгүй хувьтай тэнцүү байх бөгөөд доор дурдсан томъёогоор тооцно.

a - тонноор илэрхийлсэн нүүрсний хэмжээ

b - дуудах доод үнэ

y - дэнчингийн хувь

x - дэнчингийн хэмжээ

$$x = y * \frac{a*b}{100}$$

(Энэ заалтыг Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 13 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан)

2.15. Дэнчинг шилжүүлэхдээ гүйлгээний утга хэсэгт дараах зүйлсийг бичсэн байна. Үүнд:

- 2.15.1. компанийн улсын бүртгэлийн гэрчилгээн дээрх оноосон нэр;
- 2.15.2. арилжааны систем /comex.mse.mn/-д бүртгэгдсэн бүртгэлийн дугаар;
- 2.15.3. дэнчингийн зориулалт;
- 2.15.4. шаардлагатай бусад мэдээлэл.

(Энэ заалтыг Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 13 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан)

2.16. Дэнчинг худалдан авах санал гаргагч талд буцаан шилжүүлэх болон худалдагч талд шилжүүлэхтэй холбогдон гарах банкны гүйлгээний шимтгэлийг арилжаа зохион байгуулагч хариуцахгүй.

2.17. Нүүрсний зах зээлийн үнэ буурсан тохиолдолд худалдагчийн эрх бүхий албан тушаалтны гарын үсэг бүхий хүсэлтийг үндэслэн арилжаа зохион байгуулагч нь энэхүү зааврын 2.5-д заасны дагуу бүртгэгдсэн захиалгын дуудах доод үнэд арилжаа зохион байгуулагдах өдрөөс ажлын 1-ээс доошгүй өдрийн өмнө өөрчлөлт оруулна.

(Энэ заалтыг Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 13 дугаар тогтоолоор нэмсэн)

2.18. Арилжаа зохион байгуулагч нь энэхүү зааврын 2.17-д зааснаар дуудах доод үнийг худалдагчийн хүсэлтийн дагуу өөрчилсөн тухай өөрийн цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлнэ.

(Энэ заалтыг Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 13 дугаар тогтоолоор нэмсэн)

Гурав. Арилжааны бэлтгэл хангах

3.1. Арилжаа зохион байгуулагч нүүрсний цахим арилжаа эхлэхээс өмнө дараах бэлтгэл ажлыг хангасан байна. Үүнд:

- 3.1.1. нүүрс арилжих захиалга, түүний бүрдүүлбэрийг хүлээн авснаас хойш ажлын 2 өдрийн дотор шалгах;
- 3.1.2. худалдагчаас ирүүлсэн мэдээллийн дагуу нүүрсний цахим арилжааны зарыг www.mse.mn цахим хуудас болон нүүрсний арилжааны системд арилжаа зохион байгуулагдахаас ажлын 5-аас доошгүй өдрийн өмнө байршуулах;
- 3.1.3. арилжаа зохион байгуулагдахаас 30 минутын өмнө арилжааны дэнчинг шалгаж, худалдан авах санал гаргагчийн арилжаанд оролцох эрхийг нээх;
- 3.1.4. нүүрсний цахим арилжаа эхлэхээс өмнө болон арилжааны дундуур арилжаанд оролцогчдод зайлшгүй мэдээлэх шаардлагатай эрх бүхий байгууллагын шийдвэр, цаг үеийн бусад мэдээллийг www.mse.mn цахим хаягаар болон нүүрсний арилжааны системээр дамжуулан мэдээлэх;

3.1.5. арилжаа зохион байгуулагч нь нүүрсний арилжаанд оролцогч талуудад цахим арилжааны системийн талаарх сургалт зохион байгуулах, гарын авлагаар хангах үйл ажиллагааг өөрийн санаачилгаар болон сонирхогч этгээдийн хүсэлтээр зохион байгуулж болно.

3.2. Худалдан авах санал гаргагч нь нүүрсний цахим арилжаанд оролцохдоо дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

3.2.1. Худалдан авах санал гаргагч нь арилжааны өдөр арилжаа зохион байгуулагчаас олгосон арилжааны системд хандах эрхээр нэвтэрч арилжаанд оролцох;

3.2.2. Худалдан авах санал гаргагч нь өөрийн техник хэрэгсэл, программ хангамжийн бэлэн байдлыг хангаж арилжаанд оролцох;

3.2.3. Арилжааны системд нэвтрэх эрхийг бусдад дамжуулах, шилжүүлэх, нууцлалыг алдагдуулахгүй байх, үүнээс үүсэх хохирлыг худалдан авах санал гаргагч өөрөө бүрэн хариуцах;

3.2.4. Арилжааны системтэй холбоотой ямар нэг алдаа илэрвэл арилжаа зохион байгуулагчид яаралтай мэдэгдэж шаардлагатай арга хэмжээ авч ажиллах.

3.3. Худалдан авах санал гаргагч нь арилжааны явцад захиалгын санд оруулах үнийн саналын үнэн зөв, түүнээс үүсэх үр дагаврыг бүрэн хариуцна.

3.4. Худалдан авах санал гаргагч нь өөрийн анхаарал болгоомжгүй үйлдлээр буруу үнийн саналыг захиалгын санд оруулсан нь тухайн үнээр хийгдсэн хэлцлийг цуцлах үндэслэл болохгүй.

Дөрөв. Нүүрсний цахим арилжааг зохион байгуулах

4.1. Арилжаа зохион байгуулагч нь нүүрсний цахим арилжааг худалдагчийн нүүрс арилжих захиалгад заасан нөхцөл, үнийн саналын дагуу зохион байгуулах бөгөөд худалдахаар зарласан нийт багцыг нэг худалдан авагчид худалдана.

4.2. Нүүрсний цахим арилжааг долоо хоног бүрийн ажлын өдрүүдэд 10:00-17:00 цагийн хооронд зохион байгуулна.

(Энэ заалтад Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 13 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан)

4.3. Нүүрсний арилжаа нь дараах 3 үе шаттайгаар явагдана:

4.3.1. захиалга бүртгэх үе;

4.3.2. дуудах үе;

4.3.3. хэлцэл хийгдэх үе.

4.4. Нүүрс худалдан авах захиалга бүртгэх үед худалдан авах санал гаргагч нь худалдан авах боломжит үнийг цахим арилжааны системд оруулна.

4.5. Худалдан авах захиалга бүртгэх үе нь 60 минут хугацаанд үргэлжлэх бөгөөд энэ үед нүүрс худалдан авах захиалгыг өөрчлөх эсхүл цуцалж болно.

4.6. Худалдан авах захиалга бүртгэх үе дууссаны дараа дуудах үе нь 1 минут үргэлжлэх бөгөөд энэ үед шинээр захиалга оруулах, үнийг бууруулан захиалгад өөрчлөлт оруулах боломжгүй.

4.7. Дуудах үед худалдан авах санал гаргагч нь өөрийн оруулсан үнийн саналыг өсгөж, шинэ үнэ оруулж болох бөгөөд үнэ шинэчлэгдсэн тохиолдол бүрд дуудах үе 1 минутаас эхлэн тоологдоно.

4.8. Дуудах үеийн 1 минутын хугацаанд үнэ шинэчлэгдээгүй тохиолдолд хамгийн өндөр үнийн саналаар хэлцэл хийгдэнэ.

4.9. Энэхүү зааврын 4.8-д заасны дагуу хэлцэл хийгдсэнээр тухайн арилжаа дуусгавар болно.

4.10. Арилжаа зохион байгуулагч нь Нүүрсний цахим арилжааны журмын 6.3-д заасан үйлдэл хийгдсэн байж болзошгүй гэж үзвэл холбогдох нотлох баримтыг хавсарган Санхүүгийн Зохицуулах Хороо (цаашид "Хороо" гэх)-нд мэдэгдэнэ.

4.11. Хэрэв худалдан авах санал гаргагчийн буруутай үйлдэл нь тогтоогдвол тухайн этгээдийн нүүрсний цахим арилжааны системээр дамжуулан арилжаанд оролцох эрхийг 6-12 сарын хугацаанд түдгэлзүүлнэ.

Тав. Арилжааны дараах үйл ажиллагаа

5.1. Арилжаа зохион байгуулагч нь арилжаа дууссанаас хойш ажлын 1 өдрийн дотор баталгаажсан хэлцлийн тайланг худалдагч, худалдан авагч талд цахимаар хүргүүлнэ.

5.2. Худалдагч талд хүргүүлэх баталгаажсан хэлцлийн тайланд дараах мэдээлэл тусгагдсан байна. Үүнд:

5.2.1. худалдан авахаар шалгарсан хуулийн этгээдийн энэхүү зааврын 2.10-т заасан бүртгэлийн баримт бичиг, холбоо барих мэдээлэл, хэлцэл хийгдсэн үнэ, хэлцлийн дугаар;

5.2.2. арилжаанд оролцсон худалдан авах санал гаргагч этгээдүүдийн жагсаалт.

5.3. Худалдан авахаар шалгарсан талд хүргүүлэх баталгаажсан хэлцлийн тайланд дараах мэдээлэл тусгагдсан байна. Үүнд:

5.3.1. худалдагчийн төлбөр хүлээн авах банкин дахь дансны мэдээлэл;

5.3.2. худалдагчийн холбоо барих утасны дугаар;

5.3.3. талуудаас экспортын гэрээ байгуулах, хэлцлийн төлбөр, арилжааны шимтгэл төлөхтэй холбоотой бусад мэдээлэл.

5.4. Арилжаа зохион байгуулагч нь арилжаа дууссанаас хойш ажлын 2 өдрийн дотор арилжааны тайланг Хороонд хэвлэмэл эсхүл цахим хэлбэрээр хүргүүлнэ.

5.5. Арилжааны тайланд дараах мэдээлэл тусгагдсан байна. Үүнд:

5.5.1. худалдан авагч хуулийн этгээдийн мэдээлэл;

5.5.2. хэлцэл хийгдсэн үнэ, цаг, минут, секунд;

5.5.3. хэлцлийн дугаар;

5.5.4. арилжаа зохион байгуулагдсан он, сар өдөр;

5.5.5. арилжаа эхэлсэн болон дууссан цаг, минут;

5.5.6. арилжаанд оролцсон нийт худалдан авах санал гаргагч хуулийн этгээдүүдийн албан ёсны нэр, бүртгэлийн дугаар;

5.5.7. арилжаанд оролцсон худалдан авах санал гаргагчдын дэнчин байршуулсан талаарх баримт;

5.5.8. худалдагчийн захиалга, түүний бүрдүүлбэр;

5.5.9. шаардлагатай бусад мэдээлэл.

5.6. Арилжаа зохион байгуулагч нь арилжааны үр дүнд үүссэн төлбөрийн үүргийг тодорхойлон бүртгэл хөтөлнө.

5.7. Баталгаажсан хэлцэлд үндэслэн нүүрс худалдагч болон худалдан авагч талууд нь энэхүү зааврын Хавсралт 4-өөр баталсан “Нээлттэй цахим арилжаагаар худалдсан нүүрсний экспортын гэрээний жишиг загвар”-ыг жишиг болгон экспортын гэрээг байгуулж, ажлын 7 өдрийн дотор хэлцлийн төлбөрийг бүрэн төлсөн талаарх баримтын хамт арилжаа зохион байгуулагчид хүргүүлнэ.

5.8. Худалдагч болон худалдан авагчийн хооронд байгуулсан экспортын гэрээтэй холбоотой аливаа маргааныг арилжаа эрхлэгч хариуцахгүй.

5.9. Нүүрсний арилжааны мэдээг олон нийтэд нүүрсний арилжааны систем болон www.mse.mn цахим хуудсаар дамжуулан тогтмол хүргэнэ.

5.10. Нүүрсний арилжааны мэдээнд дараах мэдээлэл тусгагдсан байна. Үүнд:

- 5.10.1. арилжаа зохион байгуулагдсан он, сар, өдөр;
- 5.10.2. арилжаанд оролцсон нийт худалдан авах санал гаргагчдын тоо;
- 5.10.3. худалдагч хуулийн этгээдийн нэр, албан ёсны хаяг;
- 5.10.4. захиалгын бүртгэлийн дугаар;
- 5.10.5. доод үнэ;
- 5.10.6. хэлцэл хийгдсэн үнэ;
- 5.10.7. экспортын гэрээний нийт үнийн дүн;
- 5.10.8. хэлцлийн дугаар;
- 5.10.9. үнийн өсөлтийн хувь;
- 5.10.10. арилжсан нүүрсний төрөл, ангилал, чанарын үзүүлэлт;
- 5.10.11. холбогдох хууль тогтоомж, журамд заасан бусад мэдээлэл.

5.11. Арилжаа зохион байгуулагч нь хийгдсэн хэлцлийн үнийг тонн, нүүрсний төрөл, ангилал, худалдан авагчийн оршин байгаа улс, арилжаа зохион байгуулагдсан он, сар, өдөр зэрэг үзүүлэлтээр өдөр, долоо хоног, сар, жилээр тогтмол мэдээлнэ.

Зургаа. Төлбөр тооцоо

6.1. Худалдагч нь нүүрс арилжих захиалгыг бүртгэх үйлчилгээний хөлсийг багц тутамд 100,000 төгрөгөөр тооцож арилжаа зохион байгуулагчид төлнө.

6.2. Худалдагч нь бүртгэх үйлчилгээний хөлсийг энэхүү зааврын 2.2-т заасан хугацаанд төлсөн байна.

6.3. Худалдан авагч эсхүл арилжаа зохион байгуулагчийн буруутай үйлдлээс шалтгаалж тухайн арилжаа зохион байгуулагдаагүй, цуцлагдсан тохиолдолд тухайн захиалгын бүртгэх үйлчилгээний хөлсийг буцаан олгоно.

6.4. Худалдан авагч нь цахим системд хийгдсэн тухайн хэлцлийн нийт үнийн дүнгийн 0.1 хувьтай тэнцэх хэмжээний арилжааны шимтгэлийг арилжаа зохион байгуулагчид төлнө.

6.5. Арилжаа зохион байгуулагч нь арилжаа дууссан өдрөөс хойш ажлын 1

өдрийн дотор тухайн арилжааны шимтгэлийн нэхэмжлэх үйлдэн худалдан авагчид хүргүүлнэ.

6.6. Худалдан авагч нь нэхэмжлэхийг цахимаар хүлээн авснаас хойш ажлын 3 өдрийн дотор арилжааны шимтгэлийг арилжаа зохион байгуулагчийн нэхэмжлэхэд тусгагдсан дансанд шилжүүлнэ.

6.7. Арилжааны шимтгэлийг тухайн арилжааны зард тусгагдсан валютаар тооцож төлнө.

6.8. Арилжаа зохион байгуулагч нь талуудын хооронд байгуулагдсан хүчин төгөлдөр экспортын гэрээ, түүний нэмэлт өөрчлөлтийг бүртгэж, тамга тэмдэг дарна.

6.9. Арилжаа зохион байгуулагч нь худалдагч, худалдан авагч талуудын хооронд байгуулагдсан хүчин төгөлдөр экспортын гэрээ, хэлцлийн төлбөрийг бүрэн төлсөн баримт (дэнчинг хассан дүнгээр) болон арилжааны шимтгэл төлсөн баримтыг ирүүлснээс хойш ажлын 5 өдрийн дотор дэнчинг банкны гүйлгээний шимтгэлийг хассан дүнгээр худалдагчийн нэрийн дансанд шилжүүлнэ.

6.10. Худалдан авагч арилжааны шимтгэлийг хугацаандаа төлөөгүй нь экспортын гэрээг бүртгэхээс татгалзах үндэслэл болно.

6.11. Хэрэв худалдан авагч хэлцлийн төлбөрийг гэрээнд тусгагдсан нийт хэмжээгээр 100% худалдагч талд шилжүүлсэн бол худалдан авагчийн арилжаа зохион байгуулагчийн дансанд байршуулсан дэнчинг худалдан авагчийн дансанд банкны гүйлгээний шимтгэлийг хассан дүнгээр буцаан шилжүүлнэ.

6.12. Арилжаа явагдаагүй, худалдан авах санал гаргагч тухайн арилжаанд оролцоогүй, эсхүл оролцсон боловч шалгараагүй тохиолдолд арилжаа явагдаж дууссан өдрөөс хойш ажлын 5 өдрийн дотор арилжаа зохион байгуулагч нь худалдан авах санал гаргагчид дэнчинг буцаан олгох бөгөөд банкны гүйлгээний шимтгэлийг хассан дүнгээр шилжүүлнэ.

6.13. Дэнчинг буцаахдаа худалдан авах санал гаргагчийн дэнчинг шилжүүлсэн дансанд, анх орж ирсэн валютаар буцаан шилжүүлнэ.

6.14. Худалдан авах санал гаргагчийн цахимаар ирүүлсэн албан ёсны (тухайн хуулийн этгээдийн төлөөлөх эрх бүхий этгээдийн гарын үсэг болон тамга тэмдэг дарсан албан тоот) хүсэлтээр дэнчинг дараагийн арилжаанд оролцох зорилгоор арилжаа зохион байгуулагчийн дансанд хэвээр үлдээж болно.

6.15. Хэлцэл амжилттай хийгдсэн боловч Нүүрсний цахим арилжааны журмын 4.5-д заасан нөхцөл бүрдсэн тохиолдолд арилжаа зохион байгуулагч нь дэнчинг арилжааны шимтгэл болон банкны гүйлгээний шимтгэлийг хассан дүнгээр худалдагчид шилжүүлнэ. Дэнчингээс суутгасан арилжааны шимтгэлийг нүүрс худалдан авахаар шалгарсан этгээд худалдагчид нөхөн төлөх үүрэг хүлээнэ.

Долоо. Бусад

7.1. Тухайн нүүрс арилжих захиалгын дагуу арилжаа зохион байгуулагдаж, экспортын гэрээ дуусгавар болсноор арилжаа зохион байгуулагчийн арилжааны систем дэх тухайн захиалгыг бүртгэлээс хасна.

7.2. Нүүрсний цахим арилжааны журмын 4.5-д заасан нөхцөл бүрдсэн тохиолдолд дуудлага арилжаагаар хийгдсэн хэлцлийг цуцалж болох ба уг нөхцөл бүрдсэн нь арилжааны шимтгэлийг төлөхгүй байх үндэслэл болохгүй.

7.3. Нүүрсний чанарын үзүүлэлт, нүүрсний нийлүүлэлттэй холбоотой маргаан үүсэх тохиолдолд асуудлыг экспортын гэрээ болон Нүүрсний цахим арилжааны журмаар зохицуулах ба үүнээс үүдэн хэлцэл цуцлах тохиолдолд Арилжаа зохион байгуулагчид төлсөн арилжааны шимтгэлийг буцаан олгохгүй болно.

7.4. Нүүрсний цахим арилжааны явцад арилжаа зохион байгуулагчийн хүсэл зоригоос үл хамаарах нөхцөл байдлаас эсхүл түүний буруутай үйл ажиллагаанаас болж нүүрсний арилжааны системд асуудал үүсэх, тухайн арилжаа зохион байгуулагдах боломжгүй болсон тохиолдолд тухайн арилжааг цуцалж, дахин зохион байгуулна.

7.5. Энэхүү зааврын хэрэгжилтэд Хороо болон арилжаа зохион байгуулагчийн хяналтын алба, дотоод аудитын нэгж хяналт тавина.

7.6. Энэхүү заавраар зохицуулаагүй бусад харилцааг Нүүрсний цахим арилжааны журмаар зохицуулна.

~oOo~

Хавсралтууд

Хавсралт 1. Нүүрс арилжих захиалгын маягт

Хавсралт 2. Экспортод гаргах нүүрсний цахим арилжааны зарын маягт

Хавсралт 3. "Экспортод гаргах нүүрсний цахим арилжаанд оролцох бүртгэлийн гэрээ"-ний загвар

Хавсралт 4. "Нээлттэй цахим арилжаагаар худалдсан нүүрсний экспортын жишиг гэрээ"-ний жишиг загвар

НҮҮРС АРИЛЖИХ ЗАХИАЛГЫН МАЯГТ

Огноо:.....

Дугаар:.....

Улаанбаатар хот

Бид [нүүрс худалдагч аж ахуйн нэгж, түүнийг төлөөлж]

энэхүү маягт, түүнд хавсаргасан баримт бичгийн үнэн зөвийг бүрэн хариуцах бөгөөд худалдан авах санал гаргагчид хүргэвэл зохих мэдээллийг үнэн зөв, бүрэн тусгасан болно.

1.Худалдагчийн мэдээлэл:

1.1 Оноосон нэр

1.2 Бүртгэлтэй улс, улсын бүртгэлийн дугаар:

1.3 Регистрийн дугаар:

1.4 Үйл ажиллагааны чиглэл:

1.5 Оршин байх албан ёсны хаяг:
/Монгол Улсад төлөөлөгчийн газартай бол түүний хаягийг мөн бичнэ/

1.6 Шуудангийн болон цахим шуудангийн хаяг, холбоо барих утас:

1.7 Энэхүү маягттай холбоотой асуудлыг хариуцах этгээдийн нэр, албан тушаал, хаяг, холбоо барих утас:

1.8 Компанийн одоогийн гүйцэтгэх удирдлага эсхүл удирдлагын баг /байхгүй бол эрх бүхий албан тушаалтан/-ийн гишүүдийн товч мэдээлэл:

1.9 Төлбөр, тооцоог гүйцэтгэх банк,
дансны мэдээлэл:

1.10 Худалдан авагчид хүргэвэл зохих
нэмэлт мэдээлэл:

2.Арилжигдах нүүрсний мэдээлэл:

2.1 Арилжигдах нүүрсний багцын тоо
хэмжээ (тонн):

2.2 Нүүрс нийлүүлэх цэг:

2.3 Нүүрсний төрөл, ангилал:

2.4 Нүүрсний чанарын үзүүлэлт:
/Стандарт, чанарын
үзүүлэлтүүд/

2.5 Цахим нээлттэй арилжаа зохион
байгуулагдах хугацаа:

2.6 Нүүрс хүргэж өгөх хугацаа:

2.7 Нүүрс татан авах хугацаа:

2.8 Дуудах доод үнэ, вальютын
төрөл:

2.9 Дуудах үед үнэ өсгөх хамгийн
бага дүн, нэгж (tick size):

2.10 Дэнчингийн хэмжээ:

2.11 Дэнчин байршуулах дансны
дугаар.

2.12 Нүүрсний чанарын шинжилгээ
хийсэн итгэмжлэгдсэн
лабраторийн мэдээлэл:
/нэр, хаяг, холбоо барих утас/

2.13 Итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний товч дүгнэлт, чанарын үзүүлэлт:

*-Чанарын үзүүлэлтийн дээш доош өөрчлөгдөх хэлбэлзлийн хувь хэмжээг заана.

Жишиг үзүүлэлт:	
Хэмжигдэхүүн	Чанарын үзүүлэлт /Өөрчлөлтийн хувь*
Үнслэг (хуурай, %)	
Дэгдэмхий бодис (үнсгүй хуурай, %)	
Хүхэр (хуурай, %)	
Нийт чийглэг (хүлээн авах үеийн төлөв, %)	
G индекс	

/Бид энэхүү маягт болон түүнд хавсаргасан баримт, бичгийг төрийн эрх бүхий байгууллага болон олон нийтэд мэдээллэхийг зөвшөөрч байна/

Нүүрс арилжих захиалга хүргүүлсэн:

Овог, нэр:

Албан тушаал:

"....." ХХК-ийн
.....

Гарын үсэг:

(Тамга/тэмдэг)

ТУСГАЙ ТЭМДЭГЛЭЛ /зөвхөн Биржийн албан хэрэгцээнд/

Захиалга хүлээн авсан ажилтны овог, нэр:	Захиалга хүлээн авсан огноо, цаг, минут:	Захиалга, түүнд хавсаргасан баримтын тоо /нүүрээр/:

**ЭКСПОРТОД ГАРГАХ НҮҮРСНИЙ
ЦАХИМ АРИЛЖААНЫ ЗАР**

/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 13 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/

Нүүрс худалдагч болон арилжигдах нүүрсний мэдээлэл	
Нүүрс худалдагч этгээдийн нэр	
Цахим арилжаа зохион байгуулагдах огноо	
Нүүрсний багцын тоо	
Нүүрсний төрөл, ангилал	
Чанарын үзүүлэлт	
Нүүрс нийлүүлэх цэг	
Нүүрс хүргэж өгөх огноо	
Нүүрс татан авах огноо	
Дуудах доод үнэ, валютын төрөл	
Дуудах үед үнэ өсгөх хамгийн бага дүн	
Дэнчингийн хэмжээ	
Дэнчин байршуулах банкны дансны мэдээлэл, валютын төрөл	
Худалдан авагчид хүргэвэл зохих нэмэлт мэдээлэл:	

Энэхүү маягтад тусгасан мэдээллийн үнэн зөвийг худалдагч тал бүрэн хариуцна.

**ЭКСПОРТОД ГАРГАХ НҮҮРСНИЙ ЦАХИМ АРИЛЖААНД
ОРОЛЦОХ БҮРТГЭЛИЙН ГЭРЭЭНИЙ ЗАГВАР**

*/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 13 дугаар тогтоолоор өөрчлөлт
оруулсан/*

2023 оны ... дүгээр
сарын ...-ны өдөр

Дугаар:

Улаанбаатар хот

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү “Экспортод гаргах нүүрсний цахим арилжаанд оролцох бүртгэлийн гэрээ” (цаашид “Гэрээ” гэх)-г нэг талаас “Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК (цаашид “Арилжаа зохион байгуулагч” эсхүл “МХБ” гэх), нөгөө талаас “...”ХХК (цаашид “Худалдан авах санал гаргагч” гэх) нар (хамтад нь “Талууд”, дангаар нь “Тал” гэх) экспортод гаргах нүүрсний нээлттэй цахим арилжаанд худалдан авагчаар бүртгүүлэх, оролцохтой холбоотойгоор дор дурдсан нөхцлөөр харилцан тохиролцож байгуулав.
- 1.2. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 466 дугаар тогтоолоор баталсан “Экспортод гаргах нүүрсний нээлттэй цахим арилжааны тухай журам” (цаашид “Арилжааны журам” гэх)-ын 6 дугаар зүйлд заасан Худалдан авах санал гаргагч хуулийн этгээд нь “Эрдэнэс тавантолгой” ХК болон хүсэлт гаргасан БНХАУ-ын хилийн боомтоор нүүрс экспортлогч аж ахуйн нэгжийн экспортын нүүрсийг цахимаар нээлттэй арилжаалах МХБ-ийн арилжаанд сайн дурын үндсэн дээр оролцоно.

Хоёр. Гэрээний хугацаа

- 2.1. Гэрээ нь Талууд гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулсан өдрөөс хойш буюу 2023 оны ... дүгээр сарын ...-ны өдрөөс 20... оны ... дүгээр сарын ...-ний өдрийг хүртэл хугацаанд хүчин төгөлдөр байна.
- 2.2. Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээний хугацааг тухай бүр бичгээр нэмэлт өөрчлөлт оруулах замаар сунгаж болно.

Гурав. Арилжааны дэнчин

- 3.1. Арилжааны дэнчин нь Арилжааны журмын 1.2.6-д тодорхойлсон мөнгөн хөрөнгө байна.
- 3.2. Дэнчингийн хэмжээ нь Арилжааны журмын 3.7-д заасны дагуу доод үнээр илэрхийлсэн тухайн захиалгын нийт үнийн дүнгийн 5-аас доошгүй хувьтай тэнцүү байна.

- 3.3. Арилжаа зохион байгуулагч нь доод үнэ болон бусад мэдээллийг арилжаа зохион байгуулагдахаас ажлын 5-аас доошгүй өдрийн өмнө арилжааны зард тусган www.mse.mn болон www.comex.mse.mn цахим хаягт байршуулсан байна.
- 3.4. Худалдан авах санал гаргагч нь арилжааны дэнчинг арилжаа зохион байгуулагдахаас 30-аас доошгүй минутын өмнө зард тусгагдсан арилжаа зохион байгуулагчийн дансанд байршуулсан байна.
- 3.5. Арилжаа зохион байгуулагч нь арилжааны дэнчинг арилжааны зард тусгагдсан нөхцөлөөр өөрийн нэр дээрх арилжааны банкин дах дансанд хүлээн авна.
- 3.6. Хэрэв худалдан авах санал гаргагч нь арилжааны дэнчинг өөр валютаар шилжүүлсэн тохиолдолд арилжаа зохион байгуулагчийн хүлээн авсан банкны тухайн өдөр зарласан албан ёсны ханшийг баримтлан хөрвүүлж хүлээн авна.
- 3.7. Цахим системд худалдан авах санал гаргагчийн үнийн саналаар хэлцэл хийгдсэн тохиолдолд ажлын 7 өдрийн дотор Арилжааны журмын 1.2.9-д заасан экспортын гэрээг худалдагч талтай байгуулж, тус гэрээний төлбөрийг арилжааны дэнчинг хассан дүнгээр худалдагчид шилжүүлсэн баримт болон тухайн арилжааны шимтгэл төлсөн баримтын хамт арилжаа зохион байгуулагчид дээрх хугацаанд ирүүлэх үүрэгтэй.
- 3.8. Арилжаа зохион байгуулагч нь дэнчинг Гэрээний 3.7-д заасан гэрээг ирүүлсэн өдрөөс хойш ажлын 7 өдрийн дотор Худалдагчийн нэр дээрх арилжааны банкин дах дансанд банкны гүйлгээний шимтгэлийг хассан дүнгээр шилжүүлнэ.
- 3.9. Хэрэв худалдан авагч хэлцлийн төлбөрийг гэрээнд тусгагдсан нийт хэмжээгээр 100% худалдагч талд шилжүүлсэн баримтыг ирүүлсэн тохиолдолд, түүний дэнчинг анх шилжүүлсэн дансанд банкны гүйлгээний шимтгэлийг хассан дүнгээр буцаан шилжүүлнэ.
- 3.10. Хэрэв худалдан авах санал гаргагчийн үнийн саналын дагуу хэлцэл хийгдээгүй, эсхүл арилжаа зохион байгуулагдаагүй, байгуулагдсан ч амжилтгүй болсон тохиолдолд Арилжаа зохион байгуулагч нь арилжааны дэнчинг ажлын 5 өдрийн дотор худалдан авах санал гаргагчийн анх дэнчинг шилжүүлсэн дансанд буцаан шилжүүлнэ.
- 3.11. Нүүрс худалдан авахаар шалгарсан боловч экспортын гэрээг байгуулаагүй, тус гэрээний төлбөрийг худалдагч талд зохих ёсоор төлөөгүй бол Арилжаа зохион байгуулагч нь дэнчинг худалдагч талд шилжүүлнэ.
- 3.12. Худалдан авах санал гаргагчийн хүсэлтээр гэрээний 3.10-д заасан дэнчинг дараагийн арилжаанд ашиглах зорилгоор арилжаа зохион байгуулагчийн дансанд хэвээр үлдээж болно.
- 3.13. Арилжаа зохион байгуулагч нь дэнчингийн төлбөрийг буцаах болон худалдагч тал руу шилжүүлэхдээ зөвхөн зард тусгагдсан валютаар шилжүүлнэ.

Дөрөв. Арилжааны шимтгэл

- 4.1. Худалдан авах санал гаргагч нь цахим арилжаанд оролцож нүүрс худалдан авахаар шалгарсан тохиолдолд арилжааны шимтгэл төлнө.
- 4.2. Арилжааны шимтгэлийн хэмжээ нь цахим системд хийгдсэн хэлцлийн нийт үнийн дүнгийн 0.1%-тай тэнцүү байна.
- 4.3. Худалдан авах санал гаргагч арилжааны шимтгэлийг арилжаа арилжаа зохион байгуулагчийн нэхэжлэхийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 3 өдрийн дотор арилжааны зард тусгагдсан валютаар төлнө.
- 4.4. Худалдан авах санал гаргагч нь арилжааны шимтгэлийг хугацаандаа төлөөгүй тохиолдолд экспортын гэрээг бүртгэж, дэнчинг худалдагч талд шилжүүлэхээс татгалзах үндэслэл болно.

Тав. Талуудын эрх, үүрэг

- 5.1. Арилжаа зохион байгуулагч нь дараах эрхийг эдэлнэ:
 - 5.1.1. Гэрээний 4.1-т заасан арилжааны шимтгэлийг Арилжааны журмын дагуу тооцон авах;
 - 5.1.2. Арилжааны журмын дагуу дэнчинг өөрийн дансаар хүлээн авах, буцаан шилжүүлэх, нүүрс худалдан авахаар шалгарсан тохиолдолд худалдан авах санал гаргагчийн байршуулсан дэнчинг худалдагч талд шилжүүлэх;
 - 5.1.3. нээлттэй цахим арилжааны мэдээ, тайланг бэлтгэх, холбогдох хууль тогтоомж, журмын хүрээнд олон нийтэд мэдээлэх;
 - 5.1.4 худалдан авах санал гаргагч нь арилжааны шимтгэлийг хугацаандаа төлөөгүй тохиолдолд экспортын гэрээг бүртгэж, дэнчинг худалдагч талд шилжүүлэхээс татгалзах эрхтэй.
- 5.2. Арилжаа зохион байгуулагч нь дараах үүргийг хүлээнэ:
 - 5.2.1. нээлттэй цахим арилжааг зохион байгуулахад шаардлагатай техник хэрэгсэл, нэгдсэн сүлжээ, программ хангамжийн найдвартай байдлыг хангах;
 - 5.2.2. нүүрсний захиалгын дагуу цахим арилжааны зарыг арилжаа зохион байгуулагдахаас өмнө өөрийн албан ёсны цахим хуудаст байршуулах;
 - 5.2.3. дэнчинг найдвартай хадгалах, зохих журмын дагуу холбогдох этгээдэд тухай бүр шуурхай шилжүүлэх.
 - 5.2.4. экспортод гаргах нүүрсний цахим арилжаанд нүүрс худалдан авах санал гаргагчийг бүртгэх, уг этгээдээс дэнчин болон арилжааны шимтгэлийг төлөх, холбогдох гүйлгээ, шилжүүлгийг гүйцэтгэхтэй холбоотойгоор банкт хамтран ажиллах;
- 5.3. Худалдан авах санал гаргагч нь дараах эрхийг эдэлнэ:
 - 5.3.1. арилжааны цахим системд худалдан авах санал гаргагчаар бүртгүүлэн, арилжаанд оролцох;
 - 5.3.2. захиалгын зар, мэдээ болон арилжаанд оролцохтой холбоотой сургалт, гарын авлагаар хангуулах;
 - 5.3.3. нээлттэй цахим арилжааг зохион байгуулах, холбогдох төлбөр тооцоог гүйцэтгэхтэй холбоотой санал, гомдлоо Санхүүгийн Зохицуулах Хороонд гаргах.
- 5.4. Худалдан авах санал гаргагч нь дараах үүргийг хүлээнэ:
 - 5.4.1. цахим арилжааны системд худалдан авах санал гаргагчаар бүртгүүлэхдээ үнэн зөв баримт бичгийг бүрэн бүрдүүлж, Арилжаа зохион байгуулагчид өгөх;

- 5.4.2. нүүрсний арилжаанд оролцохоос өмнө дэнчинг зохих банкны дансанд байршуулах;
- 5.4.3. арилжааны шимтгэлийг хугацаандаа бүрэн төлөх;
- 5.4.4. нүүрсний арилжаанд оролцох бэлтгэл ажлыг бүрэн хангах;
- 5.4.5. арилжаа зохион байгуулагчийн шаардсанаар нэмэлт мэдээлэл өгөх ;
- 5.4.6. бусад этгээдтэй үгсэн хуйвалдах замаар нүүрсний үнийг зохиомлоор тогтоох, зах зээлийг урвуулан ашиглах зорилгоор аливаа үйлдэл хийхгүй байх;
- 5.4.7. арилжааны системд хэлцэл амжилттай биелсэн тохиолдолд Арилжаа зохион байгуулагчийн баталсан гэрээний жишиг загварыг жишиг болгон экспортын гэрээ байгуулан ажлын 7 өдрийн дотор ирүүлэх, гэрээний төлбөр худалдагчид төлөх, гэрээний хэрэгжилтийг зохих ёсоор хангаж ажиллах;
- 5.4.8. худалдан авах санал гаргагчийн анхаарал болгоомжгүйн улмаас захиалгын санд буруу алдаатай үнийн дүн, хэмжээ оруулж, түүний дагуу хэлцэл хийгдсэн тохиолдолд уг асуудлаас үүсэх хариуцлагыг хүлээх;
- 5.4.9 Энэ гэрээний 5.2.4 дэх заалттай холбоотойгоор арилжаа зохион байгуулагчид шаардлагатай мэдээллийг гаргаж өгөх.

Зургаа. Бусад

- 6.1. Гэрээтэй холбоотой Талуудын хооронд үүссэн маргаан, үл ойлголцлыг зөвшилцлийн үндсэн дээр шийдвэрлэнэ.
- 6.2. Гэрээний 6.1-д зааснаар тухайн маргаан, үл ойлголцлыг шийдвэрлэж чадаагүй тохиолдолд Талууд Монголын Олон улсын Арбитрт хандаж шийдвэрлүүлнэ.
- 6.3. Гэрээгээр зохицуулаагүй бусад харилцааг "Экспортод гаргах нүүрсний нээлттэй цахим арилжааг зохион байгуулах заавар"-аар зохицуулна.
- 6.4. Гэрээг Монгол, Англи, Хятад хэл дээр тус бүр хоёр хувь үйлдсэн нь хууль зүйн адил хүчинтэй байна.
- 6.5. Хэрэв Монгол, Англи, Хятад гэрээний утга хоорондоо зөрөх тохиолдолд Монгол хэл дээрх гэрээний утгыг зөв гэж үзнэ.
- 6.6. Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр Гэрээнд бичгээр нэмэлт, өөрчлөлт оруулна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

"МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН
БИРЖ" ТӨХК-ИЙГ ТӨЛӨӨЛЖ:

"....." ХХК/ХК-ИЙГ ТӨЛӨӨЛЖ:

"МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН
БИРЖ" ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ

"....." ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ

.....
Х.АЛТАЙ

...../...../

**НЭЭЛТТЭЙ ЦАХИМ АРИЛЖААГААР ХУДАЛДСАН
НҮҮРСНИЙ ЭКСПОРТЫН ГЭРЭЭНИЙ ЖИШИГ ЗАГВАР**
/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 13 дугаар тогтоолоор өөрчлөлт
оруулсан/

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ОГНОО
[2023-.....-.....]

ХУДАЛДАГЧ	"....." ХК/ХХК
Хаяг:	
Утас:	
Итгэмжилсэн цахим хаяг:	

ХУДАЛДАН АВАГЧ	
Хаяг:	
Утас:	
Итгэмжилсэн И-мэйл:	
Бусад холбоо барих мэдээлэл	

УДИРТГАЛ ХЭСЭГ

Энэхүү Нээлттэй цахим арилжаагаар худалдсан нүүрсний экспортын гэрээ (цаашид "Гэрээ" гэх)-г нэг талаас "....." ХК/ХХК (цаашид "Худалдагч" гэх), нөгөө талаас _____ (цаашид "Худалдан авагч" гэх) (цаашид хамтад нь "Талууд" гэх) нар нь 2022 оны дугаар сарын-ны өдөр "Монголын Хөрөнгийн бирж" ТӨХК-ийн цахим арилжааны системд амжилттай хийгдсэн багц буюу нийт ... тонн/нүүрсний төрөл, ангилал/ нүүрс (цаашид "Нүүрс" гэх)-ийг худалдах, худалдан авах ... тоот хэлцлийн дагуу эрх тэгш, нээлттэй байх зарчмын үндсэн дээр дор дурдсан нөхцөлийг харилцан тохиролцож байгуулав. Үүнд:

Нэг. Гэрээний үндсэн нөхцөл	
Нэг. Гэрээний хугацаа, Гэрээ хүчин төгөлдөр болох	<p>1.1. Энэхүү гэрээний хугацаа нь Гэрээг байгуулж, төлбөрийг бүрэн төлснөөс хойш хуанлийн ____ хоногийн дотор Талууд харилцан тохиролцсон хуваарийн дагуу Нүүрсийг нийлүүлж дуусах хүртэл хугацаагаар тодорхойлогдоно.</p> <p>1.2. Талууд Гэрээнд гарын үсэг зурж тамга дарснаар Гэрээ хүчин төгөлдөр болно.</p>

<p>Хоёр. Нүүрсний гарал үүсэл</p>	<p>2.1. Гарал үүсэл: Гэрээний дагуу нийлүүлэх Нүүрсийг Монгол улс, аймаг, суманд байрлах нүүрсний уурхайгаас (цаашид “Уурхай” гэх) олборлосон байна.</p>								
<p>Гурав. Нийлүүлэх нүүрсний хэмжээ, Нүүрс нийлүүлэх цэг</p>	<p>3.1. Нийлүүлэх нүүрсний хэмжээ: Нэг багцын хэмжээ нь 6400 тонн байх бөгөөд Гэрээгээр багц Нүүрс буюу нийт ... тонн Нүүрсийг нийлүүлнэ.</p> <p>3.2. Нүүрс нийлүүлэх цэг: Монгол Улсын Гашуунсухайт боомт дахь Чингэлэгт тээврийн терминал эсхүл БНХАУ-ын хилийн боомт дахь “Нүүрс ачиж буулгах талбай” (цаашид “терминал” эсхүл “талбай” гэх) байх бөгөөд Нүүрсийг “FCA Гашуунсухайт боомт дахь Чингэлэгт тээврийн терминал эсхүл БНХАУ-ын хилийн боомт дахь “Нүүрс ачиж буулгах талбай”” (2020 оны олон улсын худалдааны нөхцөл (Incoterms 2020)-ийн дагуу) нөхцөлөөр нийлүүлнэ. Нүүрс бүхий чингэлгийг Терминалд Худалдан авагчийн нүүрс тээврийн хэрэгсэлд ачилт хийснээр Нүүрсний эзэмшил болон холбогдох бүх эрсдэл нь Худалдагч талаас Худалдан авагч талд шилжинэ.</p> <p>3.3. Худалдагч нь Нүүрс нийлүүлэх цэгт Нүүрсийг дор дурдсан хуваарийн дагуу ачилтад бэлэн байлгана.</p> <hr style="width: 10%; margin: 10px auto;"/>								
<p>Дөрөв. Нүүрсний чанар</p>	<p>4.1. Гэрээний дагуу нийлүүлэх Нүүрс нь Монгол Улсын MNS 6457:2022 “Нүүрс, нүүрсэн бүтээгдэхүүний ангилал” стандартад заасан төрөл, ангилал, чанарын үзүүлэлтэд нийцсэн байна:</p> <p>Худалдагчийн нийлүүлэх нүүрс нь дараах чанарын шаардлага хангасан байна:</p> <table style="width: 100%; border-collapse: collapse;"> <tr> <td style="width: 80%;">Үнслэг (хуурай,%)</td> <td style="width: 20%; text-align: right;">.....</td> </tr> <tr> <td>Дэгдэмхий бодис (үнсгүй хуурай,%)</td> <td style="text-align: right;">.....</td> </tr> <tr> <td>Хүхэр (хуурай, %)</td> <td style="text-align: right;">.....</td> </tr> <tr> <td>Нийт чийглэг (хүлээн авах үеийн төлөв,%)</td> <td style="text-align: right;">.....</td> </tr> </table> <p>(ii) /Худалдагч тал шаардлагатай гэж үзвэл энэ хэсэгт БНХАУ-ын хууль тогтоомжын дагуу баяжуулсан нүүрсэнд тавигдах чанарын үзүүлэлтийг тусгаж болно./</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p> <p>4.2. Гэрээгээр нийлүүлэх Нүүрсний чанарыг Худалдагчийн</p>	Үнслэг (хуурай,%)	Дэгдэмхий бодис (үнсгүй хуурай,%)	Хүхэр (хуурай, %)	Нийт чийглэг (хүлээн авах үеийн төлөв,%)
Үнслэг (хуурай,%)								
Дэгдэмхий бодис (үнсгүй хуурай,%)								
Хүхэр (хуурай, %)								
Нийт чийглэг (хүлээн авах үеийн төлөв,%)								

	<p>Цагаанхад дахь гаалийн хяналтын талбайнаас авсан нүүрсний дээжийг итгэмжлэгдсэн лаборатори ("итгэмжлэгдсэн лаборатори" гэж Гаалийн төв лаборатори, эсхүл Монгол Улсын итгэмжлэгдсэн бусад лаборатори)-д хийгдсэн нүүрсний чанарын шинжилгээгээр тодорхойлно.</p> <p>4.3. Талуудын хооронд нийлүүлсэн нүүрсний чанарын талаар маргаан үүсвэл гуравдагч дээжийг авч, нүүрсний чанарын шинжилгээг талуудын сонгосон, магадлан итгэмжлэгдсэн хөндлөнгийн лабораторид хийлгэх бөгөөд шинжилгээний үр дүнгээр маргааныг эцэслэн шийдвэрлэнэ. Хөндлөнгийн лабораторид гуравдагч дээжийн чанарыг шинжлүүлэхтэй холбогдон гарах зардлыг талууд тэнцүү хэмжээгээр хамтран хариуцна.</p>
Тав. Жин	<p>5.1. Нүүрсний жин: Нүүрс нийлүүлэх цэг дэх нүүрсний хэмжээ нь эцсийнх бөгөөд Талуудын хүлээн зөвшөөрсөн үр дүн байна. Худалдагч нь уурхайн амнаас ачигдаж, нүүрс нийлүүлэх цэгт шилжүүлэн ачих үеийн нүүрсний жингийн зөрүүг бүрэн хариуцна. Худалдан авагч нь нүүрс нийлүүлэх цэгт шилжүүлэн ачсанаас хойш БНХАУ-ын хилийн боомт дахь талбайд буулгах үеийн нүүрсний жингийн зөрүүг бүрэн хариуцна.</p>
Зургаа. Нүүрс ачих	<p>6.1. Нүүрс ачих: Худалдан авагчаас Худалдагч талд ирүүлсэн чингэлэг болон нүүрс тээврийн хэрэгслийн мэдээллийн дагуу Худалдагч нь Нүүрс нийлүүлэх цэг дээр Нүүрсний ачилтыг зохион байгуулна.</p> <p>6.3. Худалдан авагч нь гэрээний 3.3-т заасан нүүрс нийлүүлэх хуваарийн дагуу товолсон хугацаанд зориулалтын тээврийн хэрэгслийг Нүүрс нийлүүлэх цэгт бэлэн байлгаж Нүүрсийг хүлээн авах үүрэгтэй.</p> <p>6.4. Тээврийн баримт: Худалдагч нь Худалдан авагчийн ачилт хийлгэсэн тээврийн хэрэгслийн улсын дугаар, жин (ачаагүй болон ачаатай үеийн), ачилт хийсэн огноо, ачилт эхэлсэн, дууссан цаг, хүрэх газар зэрэг холбогдох бусад мэдээлэл бүхий тээврийн баримтыг хоёр хувь үйлдэж, Талуудын албан ёсны төлөөлөгчид гарын үсэг зурж баталгаажуулан, тус бүр нэг хувийг хадгална.</p>
Долоо. Тээвэр	<p>7.1. Энэхүү гэрээний тээвэрлэлтийг Худалдагч нь уурхайн амнаас нүүрс нийлүүлэх цэг хүртэл зохион байгуулж, тээврийн төлбөрийг бүрэн хариуцна.</p> <p>7.2. Худалдагч нь гэрээт тээврийн компаниудын тээврийн хэрэгслүүдийн бүртгэлийг хийж, уурхайн нүүрс ачилтын үйл ажиллагаанд хамруулах бөгөөд Худалдан авагч нь нүүрс нийлүүлэх цэгээс нүүрс экспортлож буй тээврийн хэрэгслийн талаарх шаардлагатай бүхий л мэдээллийг Худалдагчид урьдчилан хүргүүлнэ.</p>

	<p>7.3. Нүүрс нийлүүлэх цэг хүртэлх тээврийн чингэлгийг худалдагч хариуцах тохиолдолд Худалдан авагч нь терминал эсхүл талбайд ачаатай хадгалагдаж буй өөрийн эзэмшлийн болон гэрээт чингэлэгийг тээвэрлэж, хилийн боомтоор экспортлох ба энэ хугацаанд ачаатай хүлээн авсан чингэлэгийн тоотой ижил тооны өөрийн эзэмшлийн болон гэрээт хоосон чингэлэгийг Худалдагчид үлдээсэн байна. Ачаатай чингэлэг нь БНХАУ-ын нутаг дэвсгэрт удаан хугацаагаар байршсан буюу гээгдсэн тохиолдолд Худалдагч ямар нэг хариуцлага хүлээхгүй болно.</p> <p>7.4. Хэрэв худалдагчаас терминал эсхүл талбай хүртэлх тээврийн чингэлгийг худалдан авагч хариуцах тохиолдолд цахим арилжааны зард тусгагдсан нүүрс нийлүүлэх терминал эсхүл талбайд хоосон чингэлгийг бэлдсэн байна. Худалдан авагч нь тээвэрлэлтийн үед чингэлгээс шалтгаалан тээвэрлэлтийг тасалдуулахгүй байх үүргийг хүлээнэ. Ачаатай чингэлэг нь БНХАУ-ын нутаг дэвсгэрт удаан хугацаагаар байршсан буюу гээгдсэн тохиолдолд Худалдагч ямар нэг хариуцлага хүлээхгүй болно.</p> <p>7.5. Худалдагч нь гэрээт тээврийн компанитай байгуулсан тээвэрлэлтийн гэрээний дагуу энэ гэрээний нүүрсний нийлүүлэлтийг хангана.</p>
<p>Найм. Үнэ болон төлбөрийн нөхцөл</p>	<p>8.1. Үнэ: Гэрээний дагуу нийлүүлэх нэгж тонн Нүүрсний үнэ нь нээлттэй цахим арилжааны систем дээр хийгдсэн 202... оны ... дугаар сарын ...-ны өдрийн ... тоот хэлцлийн дагуу ____ юань/ ам доллар (____) байна. Энэхүү Нүүрсний үнэнд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу төлөх НӨАТ ороогүй болно.</p> <p>8.2. Төлбөр төлөх нөхцөл: Монгол Улсын Засгийн газрын 2022 оны дугаар тогтоолоор батлагдсан “Экспортод гаргах нүүрсний нээлттэй цахим арилжааны журам”-ын 4.1-д заасны дагуу Худалдан авагч нь Гэрээний 3.1-т заасан ... тонн Нүүрсний төлбөрийг Гэрээ байгуулснаас хойш ажлын 7 өдрийн дотор дор дурдсан Худалдагчийн банканд дахь нэрийн дансанд байршуулна.</p> <p>Худалдагчийн нэрийн дансны мэдээлэл: Хүлээн авагч: ХХК/ХК Хүлээн авагчийн хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, дүүрэг, байр,..... давхар Хүлээн авагчийн банк: банк Банкны хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, дүүрэг,байр Swift код: Дансны дугаар:</p>
<p>Хоёр. Гэрээний бусад нөхцөл</p>	
<p>Ес.</p>	<p>9.1. Худалдан авагч үйл ажиллагаандаа Монгол Улсад хүчин</p>

<p>Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй болон байгаль орчин</p>	<p>төгөлдөр мөрдөгдөж буй хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчинтой холбоотой бүхий л хууль, дүрэм, журам түүнд нийцүүлэн гаргасан Худалдагчийн тушаал, шийдвэр, дүрэм журмыг дагаж мөрдөх бөгөөд өөрийн болон бусад туслан гүйцэтгэгч, гэрээт компанийн ажилтнууд (нүүрс тээврийн жолооч нарт)-д холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг танилцуулах, аюулгүй ажиллагааны сургалт зохион байгуулж, зааварчилгаа өгсөн байх үүрэгтэй.</p> <p>9.2. Худалдан авагч нь Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд заасны дагуу өөрийн гэрээт болон туслан гүйцэтгэгч компаниудтай хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг хамтын ажиллагааны гэрээнд тодорхой тусгаж оруулсан байх үүрэгтэй.</p> <p>9.3. Худалдан авагч нь терминал эсхүл талбайд Худалдагчийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, байгаль орчны зааварчилгаа, шаардлага болон Монгол улсын хууль тогтоомжийн дагуу ажиллах бөгөөд зөрчсөн тохиолдолд Худалдагчид учирсан бүхий л хохирлыг Худалдан авагч бүрэн хариуцна. Худалдан авагч нь Худалдагчийг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй болон байгаль орчны асуудлаар үүсч болох бүх төрлийн хариуцлага, нэхэмжлэл, шаардлага, алдагдал, үүрэг, зардлаас (хуульчдын бодит ажлын хөлс, мөрдөн шалгах болон маргааныг шүүхийн журмаар шийдвэрлэхтэй холбогдон үүссэн бусад зардал) ангид байлгах үүрэгтэй. Хэрэв дор дурдсан нөхцөлүүд бодитоор үүссэн тохиолдолд Худалдан авагч нь хохирлыг Худалдагчид нөхөн төлөх, түүнийг хохиролгүй болгох үүрэгтэй. Үүнд:</p> <p>9.3.1 Гэрээг хэрэгжүүлэх явцад Худалдагч эсхүл Худалдан авагчийн ажилтан, гэрээт болон туслан гүйцэтгэгч Монгол Улсын хүчин төгөлдөр хууль тогтоомж, Худалдагчийн холбогдох дүрэм, журмыг зөрчсөнөөс үүдэлтэй аливаа этгээдийн амь нас, эрүүл мэндэд хохирол учрах, нас барах, гэмтэж бэртэх зэрэг бодит хохирол учирсан;</p> <p>9.3.2 Гэрээтэй холбоотойгоор Худалдан авагч, түүний ажилтан, төлөөлөгч, гэрээт эсхүл туслан гүйцэтгэгчийн Монгол Улсын хүчин төгөлдөр хууль тогтоомж, Худалдагчийн холбогдох дүрэм, журмыг зөрчсөнөөс үүдэлтэй Худалдагчид эд хөрөнгийн хохирол учирсан.</p> <p>9.4 Худалдагч нь энэхүү гэрээний 8.3 дахь хэсэгт заасан хохирлыг заавал нөхөн төлөх нөхцөл байдал үүссэн талаар Худалдан авагчид даруи мэдэгдэх Худалдагчаас шаардсан үндэслэл бүхий бүх зүйлийг хийж гүйцэтгэнэ.</p>
<p>Арав. Нууцлал хадгалах</p>	<p>10.1. Нууцлал хадгалах болон задруулахгүй байх: Талууд Гэрээний нууцлалыг чандлан хадгалах бөгөөд аль нэг талын бичгээр зөвшөөрснөөс бусад тохиолдолд гуравдагч этгээдэд задруулж болохгүй. Дор дурдсан нөхцөлд Талуудын аль нэг нь нөгөө талаасаа бичгээр зөвшөөрөл авах шаардлагагүй. Үүнд: (a) Толгой болон харилцан хамаарал бүхий компанид мэдээлэл өгөх бол; (b) Хууль тогтоомжийн дагуу шаардсан; (c) Талуудын аль нэг нь шүүхийн болон бусад хэрэг маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд холбогдсон; (d) Монгол Улсын</p>

	<p>болон бусад хөрөнгийн биржийн журам, хууль тогтоомжийн дагуу нээлттэй болгох; (е) Талууд хараат бус нягтлан бодох бүртгэл болон хуулийн фирмд Нууцлалын гэрээ байгуулсаны үндсэн дээр өгөх мэдээлэл.</p> <p>Худалдагч нь эрх бүхий төрийн байгууллага, хууль тогтоомжийн дагуу шаардсанаар болон дээр дурдсан заалтуудад заасны дагуу Гэрээ, түүнд тухай бүр оруулсан нэмэлт, өөрчлөлтийн хувийг холбогдох байгууллагад гаргаж өгөх, системд бүртгүүлэх, нээлттэй болгох тохиолдолд энэ тухай Худалдан авагчид мэдэгдэж, зөвшөөрөл авах шаардлагагүй.</p> <p>Худалдагч нь өөрийн хагас жилийн болон жилийн эцсийн тайлан эсхүл бусад баримт бичигт Худалдан авагчийн нэр, бизнесийн харилцааны мэдээллийг Худалдан авагчаас аливаа зөвшөөрөл, баталгаажуулалт авахгүйгээр дурдах эрхтэй ба Худалдан авагч нь мөн адил ийм эрхтэй болно.</p>
<p>Арван нэг. Гэрээг зөрчсөнөөс үүсэх хариуцлага</p>	<p>11.1. Худалдагчийн хүсэл зоригоос үл хамаарах нөхцөл байдлаас бусад түүний буруутай үйл ажиллагааны улмаас Гэрээнд заасан хугацаанд Нүүрсийг нийлүүлэх цэгт бүрэн хүргээгүй бол хугацаа хэтэрсэн хоног тутамд нийлүүлэх цэгт хүргээгүй Нүүрсний үнийн дүнгийн 0.1%-тай тэнцэх алдангийг Худалдан авагчид төлнө.</p> <p>11.2. Худалдан авагч нь Гэрээнд заасан хугацаанд худалдан авсан Нүүрсээ нүүрс нийлүүлэх цэгээс бүрэн татан аваагүй бол хугацаа хэтэрсэн хоног тутамд татан аваагүй Нүүрсний үнийн дүнгийн 0.1%-тай тэнцэх хэмжээний алдангийг Худалдагчид төлнө.</p> <p>11.3 Худалдан авагч нь цахим арилжааны зард тусгагдсан өдөр терминал эсхүл талбайд хоосон чингэлгийг байрлуулаагүй бол хугацаа хэтэрсэн хоног тутамд татан аваагүй Нүүрсний үнийн дүнгийн 0.1%-тай тэнцэх хэмжээний алдангийг Худалдагчид төлнө.</p>
<p>Арван хоёр. Маргаан шийдвэрлэх</p>	<p>12.1. Гэрээтэй холбоотой гарсан саналын зөрүү, маргааныг Талууд харилцан тохиролцож, эвийн журмаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ.</p> <p>12.2. Гэрээний 12.1-т зааснаар тухайн саналын зөрүү, маргааныг шийдвэрлэж чадаагүй бол Талууд Монголын Олон улсын Арбитрт хандаж шийдвэрлүүлнэ.</p>
<p>Арван гурав. Давагдашгүй хүчин зүйл</p>	<p>13.1. Дайн бүхий байдал, зэвсэгт мөргөлдөөн, бослого, үймээн, цэргийн үйл ажиллагаа, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр, хорио цээр, ажил хаялт буюу бусад хөдөлмөрийн маргаан, бослого, нийтийг хамарсан эмх замбраагүй байдал, жагсаал цуглаан, халдварт өвчин, дэлбэрэлт, хориг арга хэмжээ, үйлдвэрлэлийн осол, гал түймэр, үер, байгалийн бусад гамшиг гэх мэт Талуудын хүсэл зоригоос гадуурх, Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхэд бодитой саад учруулах нөхцөл байдал зэрэг давагдашгүй хүчин зүйлийн улмаас аль нэг тал Гэрээгээр хүлээсэн үүргээ бүхэлд нь эсхүл хэсэгчлэн биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд тухайн тал Гэрээгээр хүлээсэн үүргээс давагдашгүй хүчин зүйлийн үргэлжлэх хугацаатай тэнцүү хугацаагаар чөлөөлөгдөнө.</p>

	<p>13.2. Давагдашгүй хүчин зүйлийн улмаас Гэрээний үүргээ биелүүлэх боломжгүй болсон тал давагдашгүй хүчин зүйлийн тухай мэдээлэл, тодорхойлолтыг эрх бүхий байгууллагаас бичгээр авч нөгөө талд арав (10) хоногийн дотор хүргүүлнэ.</p> <p>13.3. Давагдашгүй хүчин зүйлд өртсөн тал Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхэд чиглэсэн бүхий л бололцоот арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.</p> <p>13.4. Давагдашгүй хүчин зүйл нэг сараас илүү хугацаагаар үргэлжилсэн тохиолдолд Гэрээг хэсэгчлэн болон бүхэлд нь цуцлах талаар Талууд харилцан тохиролцож болох бөгөөд ийнхүү цуцлах тохиолдолд хамгийн багадаа жар (60) хоногийн өмнө нөгөө талдаа албан ёсоор бичгээр мэдэгдэл өгнө. Талуудын аль нь ч i) Гэрээ цуцлах шийдвэрээс өмнөх хийгдсэн Нүүрс нийлүүлэлт, ii) Гэрээ цуцлах өдөр хүртэл хуримтлагдсан аливаа үүрэг, хариуцлагаас бусад Гэрээг бүхэлд нь болон хэсэгчлэн цуцлахтай холбоотой үүрэг хариуцлага хүлээхгүй.</p>
Арван дөрөв. Гэрээгээр зохицуулаагүй бусад харилцаа	14.1. Гэрээгээр зохицуулаагүй бусад харилцааг Монгол Улсын хууль тогтоомж болон Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 466 дугаар тогтоолоор баталсан "Экспортод гаргах нүүрсний нээлттэй цахим арилжааны журам"-д заасныг баримтлан шийдвэрлэнэ.
Арван тав. Нэмэлт өөрчлөлт	15.1 Гэрээнд оруулах аливаа нэмэлт, өөрчлөлт нь бичгээр үйлдэгдэж, Талууд гарын үсэг зурж, компанийн тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болно.
Арван зургаа. Гэрээний хэл, үйлдэх хувь	16.1. Гэрээг Монгол, Хятад, Англи хэл дээр 5 хувь үйлдэх бөгөөд эдгээр хувиудын хооронд зөрүү гарсан тохиолдолд Монгол хэл дээрх хувийг баримтална.

Гэрээ байгуулсан:

Худалдагч: ХХК/ХК

Худалдан авагч:.....ХХК/ХК

.....

.....

.....

.....